



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**Байгалийн нөөцийн хамтын менежментийн
нөхөрлөлийн чадавхыг бэхжүүлэх талаар
авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Байгалийн нөөцийн хамтын менежментийн тогтолцоог боловсронгуй болгох, байгаль хамгаалах нөхөрлөлийн чадавхыг бэхжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай:

1/байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих, статусыг тодорхой болгох, нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хариуцан хамгаалж буй нутаг дэвсгэрийнхээ байгалийн нөөцийг давуу эрхтэйгээр ашиглах, байгаль хамгаалахад зарцуулсан зардлыг байгалийн нөөцийн төлбөрийн орлогоос буцаан олгох замаар нөхөрлөлийн санхүүгийн тогтвортой механизмыг бий болгох чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, зохиох арга хэмжээг авах;

2/нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг нэгдсэн зохион байгуулалт, салбар дундын удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд нөхөрлөл хариуцсан нэгж ажиллуулах, энэ чиглэлийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх;

3/байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагаанд олон улсын туршлага, арга зүйд үндэслэсэн, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга технологи, менежментийг нэвтрүүлэх, шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангахад чиглэсэн санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх төсөл, хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

4/байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гишүүд, идэвхтэн байгаль хамгаалагчдыг мэргэжил арга зүйн дэмжлэг, мэдлэг, мэдээллээр тогтмол хангах, давтан сургалтад хамруулах, үнэмлэх, таних тэмдэгээр хангахад шаардагдах зардлыг төлөвлөж, улсын төсөвт жил бүр тусгуулах арга хэмжээ авах.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийн талаар 2015 оны 4 дүгээр улиралд багтаан Байнгын хорооны хуралд танилцуулахыг байгаль орчин, нөгөөн хөгжил, аялал жуулчлалын яам /Д.Оюунхорол/-нд үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

С.БАТБОЛД

